



УЛААНБААТАР ХОТЫН
ШУУРХАЙ УДИРДЛАГА, ЗОХИЦУУЛАЛТЫН ТӨВ ОНӨААТҮГ
ДАРГЫН ТУШААЛ

2018 оны 09 сарын 13 өдөр

Дугаар А/18

Улаанбаатар хот

Хөрөнгө гаргах тухай


Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 33.4, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2013 оны 145 дугаар тогтоолоор батлагдсан “Улаанбаатар хотын Шуурхай удирдлага, зохицуулалтын төв” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын дүрмийн 4 дүгээр хэсгийн 4.9.9 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Улаанбаатар хотын нийтийн үйлчилгээ, болон инженер хангамжийн бүрэлдэхүүн байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт мониторинг хийх телехяналтын камер, сэлбэгийн нөөц /багц-1/, ухаалаг мэдрэгч, сэлбэгийн нөөц /багц-2/ бүрдүүлэх худалдан авалтын гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Ерөнхий диспетчер /Г.Ганзориг/-д үүрэг болгосугай.

2. Дээрх /багц-1 9,700,000/, /багц-2 9,900,000/ худалдан авалтад шаардагдах 19,600,000 /Арван есөн сая зургаан зуун мянган/ төгрөгийг холбогдох зардлаас гаргахыг Ахлах нягтлан бодогч /М.Ичинхорлоо/-д зөвшөөрсүгэй.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод хяналт, хамтын ажиллагаа хариуцсан Ахлах мэргэжилтэн /Н.Батсүх/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ч.ГАН-ОЧИР

2150300112